



СҮХБААТАР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 24

Баруун-Урт

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.7 дахь заалт, "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай" хуулийн 4.4.1 дэхь заалт, 15 дугаар зүйлийн 15.2.1 дэхь заалт, Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 21-ны өдрийн 322 тоот тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавих, баталгаажуулах, акт, баримт бүрдүүлэх, хүлээн авах, санхүүжилт олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.


Хоёр. Уг тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс /Д.Ариунжаргал/-д, Хүнс Хөдөө Аж Ахуйн газар /Л.Ган-Очир/-т, Мал эмнэлгийн хэлтэс /Л.Тунгалаг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны  
04 сарын 25 өдрийн 21 тоот  
Тогтоолын хавсралт



**МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД ХЯНАЛТ  
ТАВИХ ,БАТАЛГААЖУУЛАХ, АКТ, БАРИМТ БҮРДҮҮЛЭХ , ХҮЛЭЭН АВАХ, САНХҮҮЖИЛТ  
ОЛГОХ ЖУРАМ**

2016.04.21

**1. Нийтлэг үндэслэл**

Энэхүү журмын зорилго нь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулах, сумдын мал эмнэлэг, үржлийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч мэргэжилтний ажлын хариуцлагыг дээшлүүлэх, мал эмнэлгийн бүх шатны бүртгэл мэдээллийн тогтолцоог сайжруулах, улсын болон орон нутгийн төсвөөс олгогдож байгаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд тавигдах санхүүгийн болон дотоод хяналтыг боловсронгуй болгоход чиглэгдэнэ.

**2. Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, акт баримт бүрдүүлэх**

2.1 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд нь тухайн жилийн төлөвлөгөөт даалгаврын дагуу сум, багийн Засаг дарга, МЭҮТасагтай болон хариуцсан баг, хэсгийн өрх суурийн малчинтай байгуулсан гэрээний үндсэн дээр мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, тарилгыг графикт хугацаанд технологийн дагуу гүйцэтгэн малчин өрхийн "Малын эрүүл мэндийн дэвтэр"-т тэмдэглэгээ хийнэ.

2.3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, тарилга хийсэн тухай акт болон хавсралтыг газар дээр нь 3 хувь үйлдэн малчны тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулна.

2.4. Тухайн төрлийн вакциныг графикт хугацаанд багтаан хийж дуусмагц /10-15 хоногийн дотор/ акт баримт, холбогдох материалыг бүрдүүлэн сумын МЭҮТасагт ирүүлнэ.

2.5. Малд тарилга хийсэн актыг нэгтгэн цувааг хавсралтаар гаргаж байгаа бол хүснэгтийн дугаарын дагуу малчны гарын үсэг, тамга тэмдэгийн баталгаажуулалтыг тусгай загварын дагуу үйлдүүлж хавсаргана. /малчны тамгыг давхардуулан дарахыг хориглоно/

2.6. Хавсралтын хуудас бүрийн талын дүнг сумын МЭҮТ-ийн малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнээр хянуулах ба тарилга хийсэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч тамга, тэмдэг, гарын үсгээр баталгаажуулсан байна.

**Гурав. Акт, баримт материалыг хүлээн авах, хянах, баталгаажуулах**

3.1. Сумдын МЭҮТасгийн Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн МЭҮН-ийн малын эмчээс акт, баримт материалыг хүлээн авсны дараа 5-7 хоногт багтаан нэг бүрчлэн хянаж гарын үсэг, тамгаар баталгаажуулна.

3.2. Сумдын МЭҮТасгийн Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн дараах акт, баримт, материалыг ХХААГ-т 6, 9, 11-р сарын 10-ны дотор хугацаа алдалгүй хүргүүлнэ. Үүнд:

3.2.а. Тухайн арга хэмжээг зохион байгуулсан тухай сум, багийн Засаг даргын тодорхойлолт, Засаг даргын захирамжаар гүйцэтгэсэн бол захирамжийн хуулбар, МЭҮН-үүдэд санхүүжилт олгохыг уламжилсан албан тоот.

3.2.б. Малд тарилга хийсэн акт /УМЭА маягт № 32/ болон тарилга хийсэн цуваа /малчны тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажсан, МЭҮТ-ийн малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнээр хянуулсан/

3.2.в. Хийгдсэн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга вакцины нэр, хамрагдсан малын төрөл, тоо толгой, үйлчилгээний хөлсөнд авах санхүүжилтийн нэгдсэн товчоо.

3.2.г. Тухайн МЭҮН-ийн санхүүжилт хүссэн албан тоот, нэхэмжлэл /тамга тэмдэг бүхий/

3.2.д. ХХААГ-аас хуваарилан олгосон эм, биобэлдмэлийн зарлагын падааны хуулбар

3.2.е. Шаардлагаар нэмэлтээр авсан болон бусад нэгжээс шилжүүлэн авсан эм бэлдмэлийн падааны хуулбар

3.2.ё. Зарцуулсан биобэлдмэлийн шил, савыг ХХААГ-т буцаан тушаасан баримт

3.3. Малын эрүүл мэнд бүртгэл мэдээлэл хариуцсан эмч нь мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын төрөл тоог акт баримтанд үндэслэн "Малын үндэсний бүртгэл, мэдээллийн сан"-д шивж оруулна.

3.4. Малд угаалга, туулгалт, боловсруулалт хийсэн актыг УМЭА33 маягтаар, халдваргүйжүүлэлт хийсэн актыг УМЭА34 маягтаар тус тус гарган мэдээ тайлангийн хамт дээрх журмын дагуу ирүүлнэ.

3.5. Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний вакцинжуулалтыг холбогдох дээд байгууллагаас ирүүлсэн заавар, удирдамжийн дагуу гүйцэтгэн акт, баримт, материалыг энэхүү журмын 3.2.а-аас 3.2.ё-д зааснаар бүрдүүлэн зурагжуулсан тайлангийн хамт ирүүлнэ.

3.6. Сумдын МЭҮТ-аас ирүүлсэн акт, баримт материалыг МЭХ-ийн бүртгэл, мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн хүлээн авч нэгтгэн цэгцэлж, халдвартын эмч төлөвлөгөөт арга хэмжээтэй тулгалт хийж, МЭХ-ийн дарга буюу малын ерөнхий эмчид хүлээлгэн өгнө.

3.7. МЭХ-ийн дарга, ХХААГ-ын нягтлан бодогч, ХХААГ-ын дотоод аудитын ажлын хэсэг хамтран акт, баримтыг нягтлан хянаж баталгаажуулан 6, 9, 11 сарын 15 –ны дотор ХХААГ-ын зөвлөлд танилцуулна.

3.8. ХХААГ-ын дотоод аудитын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг акт, баримтыг шаардлагатай тохиолдолд сум, баг, өрхийн түвшинд малчин өрхийн малын эрүүл мэндийн дэвтэртэй тулгалт хийн хяналт тавьж баталгаажуулна.

3.9. Гоц халдварт өвчний тарилгын акт баримтыг аймгийн мэргэжлийн хяналтын газрын байцаагчаар хянуулан тухайн үед нь дүгнэлт гаргуулах ба халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний акт баримтанд төлөвлөгөөт хяналт хийлгэнэ.

### **Дөрөв. Санхүүжилт хуваарилах, олгох**

4.1. Тухайн жилд хийгдэх халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан шинжилгээ, тарилганд хамрагдах мал амьтны тоог үндэслэн МЭҮНэгж бүрт олгогдох санхүүжилтийн хуваарийг малын ерөнхий эмч, халдвартын их эмч тооцон гаргана

4.2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний үйлчилгээний хөлсийг Аймгийн ИТХ-аар батлагдсан "Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний жишиг үнэлгээ"-г баримтлан тооцно.

4.3. Тухайн жилийн төлөвлөгөөт арга хэмжээнд тусгагдаагүй боловч зайлшгүй шаардлагаар болон нэмэлтээр хийгдэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, вакцины үйлчилгээний хөлсийг сумын Мал хамгаалах сан болон бусад эх үүсвэрээс шийдвэрлэнэ.

4.4. Мал эмнэлгийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор эхний улиралд санхүүжилтийн 20 хүртэл хувийг урьдчилгаа байдлаар олгон дараа тооцооноос суутган тооцно.

4.5. Үлдэгдэл 80 хувийн үйлчилгээний хөлс, санхүүжилтийг вакцин, тарилга хийсэн акт, баримтанд үндэслэн гүйцэтгэлээр олгох ба урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээний 60-аас дээш хувь нь 2 дугаар улиралд, үлдсэн хувь нь 3 дугаар улиралд графикт хугацаандаа чанартай хийгдэн акт баримтаа журмын дагуу бүрдүүлэн ирүүлнэ.

4.6. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц, хэрэгжилтийг ХХААГ-ын зөвлөлөөр хэлэлцэн МЭҮН-үүдэд санхүүжилт олгуулах тухай дүгнэлт гарган 6, 9, 11 сарын 15-ны дотор аймгийн Төрийн сангийн хэлтэст албан тоотоор хүргүүлнэ. Аймгийн Санхүү, төрийн сангаас ААН-дэд улирал бүрийн сүүлийн сард багтаан олгоно.

4.7. Тухайн жилийн бүх акт, баримтыг 11 сарын 15-ны дотор эцсийн байдлаар авч нэгтгэх ба байгууллагын дотоод аудитын ажлын хэсгийг томилон сумдын МЭҮТасаг, МЭҮН-ийн түвшинд хяналт, үнэлгээ хийж дутагдал, зөрчлийг арилгуулан 4 дүгээр улирлын санхүүжилтийг хэрхэн олгох асуудлыг шийдвэрлэнэ.

4.8. Тухайн жилд аймгийн мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд төсөвлөгдсөн орон нутгийн санхүүжилтийн 2 хувийг ХХААГ-т технологийн хяналтын зардалд суутган урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц, хэрэгжилтийг хянах дотоод хяналтын зардалд зарцуулна.

#### **Тав. Харилцан хүлээх үүрэг, хариуцлага**

5.1. ХХААГ-ын МЭХ-ийн зүгээс халдварт өвчний урьдчилан сэргийлэх эм бэлдмэлийг цаг хугацаа алдалгүй нийлүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал санхүүжилтийг хугацаанд нь олгох үүрэг хүлээнэ.

5.2. Сумдын МЭҮТасгийн малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн акт баримтыг хугацаанд нь журмын дагуу бүрдүүлж ирүүлээгүй, мэдээ тайлан тасалсан, хугацаа хожимдуулсан, буруу зөрүү гаргасан тохиолдолд Хөдөлмөрийн хууль, салбарын бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. МЭҮН-ийн мэргэжилтнүүд акт баримтаа хугацаанд нь бүрдүүлэн өгөөгүй тохиолдолд тухайн тарилгын үйлчилгээний хөлсийг суутган тооцох, олгогдохгүй байх үндэслэл болно.

5.4. Энэхүү журмыг хэрэгжүүлэх явцад Төрийн сан, аудитын байгууллага болон байгууллагын дотоод аудитын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалыг арилгуулах, залруулах арга хэмжээ авч, заавар, зөвлөмж, хугацаатай үүрэг өгч ажиллана.

5.5. Заавар, зөвлөмжийн дагуу зөрчил, дутагдлаа арилгах, залруулах асуудлыг буруутай этгээд заасан хугацаанд нь хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

5.6. Төлбөр торгууль ноогдуулах, ноцтой зөрчил илэрсэн тохиолдолд тухайн асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

ХХААГ-ын Мал эмнэлгийн хэлтэс